



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/136

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/104 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг дарга, Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг дүгнэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн сайдын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/104 дүгээр тушаалын дагуу Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн гэрээг тухайн жилийн хагас бүтэн жилээр үнэлж дүгнэж тухай бүр аймгийн Засаг даргад танилцуулж байхыг ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Ч.Ганбаатар), мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газар (М.Үүрийнбаяр), гэрээнд тусгагдсан үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны  
04 дүгээр сарын 27-ны өдрийн А/ХЗБ  
дугаар захирамжийн хавсралт



## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн  
бодлогын хэлтсийн дарга

Гишүүдэд:

- Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга
- Эрүүл мэндийн газрын Анхан шатны тусламж хариуцсан мэргэжилтэн
- Эрүүл мэндийн газрын Тархвар судлаач их эмч
- Эрүүл мэндийн газрын Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй  
байдлын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
- Эрүүл мэндийн газрын Хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн
- Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга
- Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн албаны дарга
- Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн
- Өрхийн анагаахын үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл
- Сумын эмч мэргэжилтний салбар холбооны тэргүүн
- "Хөвсгөлийн хөгжил дэвшил" төрийн бус байгууллагын төлөөлөл

Нарийн бичгийн дарга: Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн  
төвийн дарга

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_